

## МОНГОЛ ХЭЛНИЙ НЭРИЙН ХАМААТУУЛАХ АЙН ЗАРИМ ОНЦЛОГ

Г. Буянтогтох \*

Монгол хэлний нэр үгэлбэрийн нэгэн өвөрмөц ай бол хамаатуулах ай юм. Хамаатуулах ай, түүнийг илтгэх арга орчин цагийн монгол хэл аялгуу нийтэд диалектикийн ерөнхий айн ёсоор, түгээмэл шинжтэй; тусгай айн ёсоор хэл аялгуу болгонд өвөрмөц онцлогтой байна. Хамаатуулах утгат бүтээвэр үүсэл гарлын хувьд гурван биеийн төлөөний үгээс салбарлан хөгжиж, халимаг, буриад, халх, дагуурын гэх мэтээр ялгарах өөр өөрийн олон хувилбартай болон төлөвшжээ. Үүнд, “. . . монгол үндэстний хамгийн анхны бөгөөд тоо чанараараа шалгарсан, хамгийн сайн хэлний материал болж буй . . . “ (Озава.2002.х.9)<sup>1</sup> “Монголын нууц товчоон”-ы хэлнээс эхлээд орчин цагийн монгол хэл буюу Монгол Улсын Төрийн хэл хүртэлх бүх монгол хэл аялгуунд нэр үгийн хамаатуулах айг илтгэх тусгай бүтээврийг үе дамжуулан, тогтвортой хэрэглэсээр ирсэн, хэрэглэж буй ч “Монголын нууц товчоо” зохиохоос бүр өмнөх хэдэн мянган жилд монгол хэлний нэр үгийн энэхүү ай ямар арга, хэрэглүүрээр хэрхэн илэрч байсан, ямар замаар яаж хөгжиж хувьсаж ирснийг шууд гэрчлэн харуулах бичиг зохиолын томоохон дурсгал, үнэлэлт дүгнэлт гаргахад хангалттай хүрэлцэхүйц жишээ баримт үлдээгүй тул манж-хамниган, казах-түрэг зэрэг төрөл хэлний харгалзах бүтээвэр болон одоогоор олоод буй зарим нэг дурсгал, үе үеийн олон монгол хэл аялгууны жишээ баримт, ялангуяа нэр үгийн хамаатуулах айн нөхцөл энэ талын судалгаанд үнэ цэнтэй чухал хэрэглэгдэхүүн, үлгэр жишээ, чиг баримжаа болох юм.

Одоогоос найман зуу шахам жилийн тэртээх монгол дурсгал бичигт “. . . *duwa - soqor aqa inu* . . . “ (1), “. . . *qarciqai - ba`an o`oru`at otcu* . . . “ (2) гэх мэтээр *-inu*, *-ba`an* зэрэг хамаатуулах нөхцөлийг нэлээд хэрэглэсэн байгаа бөгөөд тэдгээр нөхцөлийн утга болон ийм нөхцөлтэй үгэлбэр, өгүүлбэрийн утгыг монгол бичиг төсөөлөн мэдэх өнөөгийн ямар ч хүн ойлгож ухахад ноцтой саад тотгор үл учирна. Бас, “. . . монгол бичгийн хэл дундад үеийн монгол хэлний хэрэглэгдэхүүнээс хамаагүй түрүү үеийн (лавтай VII-VIII зууны монгол хэлний) онцлогийг тусгаж

\* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн Хэл шинжлэлийн тэнхим

<sup>1</sup> Ш.Озава. Монголын нууц товчооны ертөнц. УБ.2002

харин ч табгач хэлний үгийн дуудлагыг сэргээсэн байдалд илүү ойртож очдог” болох нь “ . . . монгол хэлний түүхийн баримт сэлт, тухайлбал, нангиад галигаар тэмдэглэгдэн үлдсэн эртний монгол хэлний жишээ, сянби хэлний аялгуу болох табгач хэлний дурсгал, хитан хэлний хийгээд дундад үеийн монгол хэлний хэрэглэгдэхүүн, бас нутгийн аялгууны баримт сэлттэй . . . ” (Шагдарсүрэн.1991.х.133)<sup>2</sup> харьцуулсан судалгаагаар нэгэнт тодорхой болжээ.

“Монголын нууц товчоо” туурвисан цагаас Бобровниковын “Халимаг монгол хэлний зүй” зохиосон үеийг хүрэхэд 600-гаад жил болсон бөгөөд “Монголын нууц товчоонд” *мину, чину, ману, тану* гэж бичиж дуудан, хамаатуулах утга илтгэж байсан төлөөлөх үгэлбэрийг “Халимаг монгол хэлнийзүйд” *мини, чини, мани, тани* хэмээн бичих болж, эдгээрийг Бобровников “Дүрэм бус төлөөний үг” (Бобровников.1849.с.116)<sup>3</sup> гэж нэрлэсэн байна. Тэгвэл, Табгач хэлний үе буюу VII-VIII зууны үеэс “Монголын нууц товчооны” үе хүртэл мөн л 600-гаад жил өнгөрсөн ба энэ хугацаанд монгол хэлний нэр үгийн хамаатуулах ай, түүний илрэх арга хэрэглүүр эртний үеийнхээсээ бараг ондоошоогүй гэдгийг дээр дурдсан “Монголын нууц товчооны” хэлэнд буй *мину, чину, ману, тану* болон “Халимаг монгол хэлний зүйд” жишээ болгосон *мини, чини, мани, тани* үгэлбэрийн харьцууллаас мэдэхэд түвэггүй бөгөөд ер нь, энд дурдсан бүхэнд тулгуурлан, ийм удаан жилийн түүхийн зам туулсан монгол хэлний нэр үгийн хамаатуулах ай, түүнийг илтгэх арга хэрэглүүр энэ бүх хугацааны туршид хэлзүйн утга, үүргийн талаар нэлээд тогтвортой байж, зөвхөн нөхцөл бүтээврийн бичлэг, дуудлага бага зэрэг өөр болсноос бусдаар төдийлөн хувираагүй гэсэн дүгнэлтэд хүрч болохоор байна.

Өнөөгийн байдлаар, орчин үеийн олон монгол хэл аялгууны зарим нь хоорондоо харьцангуй ойр, тэдгээрээр харилцахад тийм ч бэрх бус, харин зарим нь бие биеэс нэлээд холдож, ойлголцох нэвтрэлцэхэд түвэгтэй болсон байгаа учраас монгол хэлний нэр үгэлбэрийн хамаатуулах айн тухай ярихын тулд юуны өмнө энэ бүлэгт багтах хэлнийг авианзүй, хэлзүй, үгийнсангийн онцлог, хөгжил хувьслын хэмжээ, хоорондын холбоо хамаарал, харилцан нэвтрэлцэх байдал зэрэгт тулгуурлан, монгол хэл, монголжин хэл гэж ангилах шаардлагатай санагдана. Үүнд, харилцан нэвтрэлцэхэд онцын бэрхшээлгүй байгаа хэлнүүд буюу Монгол Улсын Төрийн хэлийг түүний нутгийн аялгуу, салбар аман аялгууны хамтаар орчин цагийн монгол хэл; Буриад Улсын монголчуудын хэл аялгууг буриад хэл; Өвөр Монголын Өөртөө засах орны монголчуудын хэл аялгууг өвөр монгол хэл; Халимаг Улсын монголчуудын хэлийг халимаг хэл хэмээгээд, эдгээрийг **монгол хэл**; харин, хоорондоо ойр төстэй боловч, дээр дурдсан монгол хэлнээс нэлээд холдож, шууд харилцан нэвтрэлцэх боломжгүй болсон баоань, дагуур, дүншиан, могол, монгор, шар уйгур хэлийг **монголжин хэл** хэмээн нэрлэж байгаа бөгөөд нэр үгийн хамаатуулах ай, түүнийг илтгэх арга хэрэглүүрийн судалгаанд суурь тулгуур болох дагуур болон монгол хэлний хэрэглэгдэхүүн элбэг хүрэлцээтэй байна. Гэтэл, дагуураас бусад монголжин хэлний биеийн хамаатуулах ёс, түүний нөхцөлийн онцлогийг тодруулахад чухал хэрэгтэй жишээ баримт ховор байгаа учраас энэ

<sup>2</sup> Ц.Шагдарсүрэн.Монголчуудын утга соёлын товчоон.УБ.1991

<sup>3</sup> А.А.Бобровников. Грамматика монгольско-калмцыкого языка. К.1849

тухайд далайцтай судалгаа хийх шаардлагатай бөгөөд жишээ баримт тийнхүү ховор буйн шалтгааныг эдгээр монгол хэлтэн олон зууны турш бусад монголчуудаас нэлээд саланги тусгаар нөхцөлд, төрөл бус хэлтний хэл, соёл, аж байдал, ахуй амьдралын хүрээлэл дунд оршиж ирсний улмаас унаган хэл сэтгэлгээ нь эвдрэн алдагдсан гэдгээр тайлбарлаж болно гэж бодож байна. Түүнчлэн, буриад монгол, халимаг монгол, өвөр монголчууд өөр зуураа болон орчин цагийн монгол хэлтэнтэй өөр өөрийн хэл аялгуугаар санаа бодлоо саадгүй нэвтрүүлж, харилцан ойлголцоход ноцтой бэрхшээл учрахааргүй буй хэдий ч тус тус нэгэн Өөртөө засах орны албан ёсны хэл мөнийх нь хувьд тэдгээрийг тусгаар монгол хэлэнд тооцож байгаа юм.

Монгол болон дагуур хэлэнд нэр үгийн хамаатуулах айн утгыг илтгэхэд доорхи нөхцөлийг хэрэглэдэг. Үүнд,

#### Нэг.Ерөнхийлөн хамаатуулах нөхцөл:

**-аа (аан), -ээ (ээн), -оо (оон), -өө (өөн), -гаа, -гээ, -гоо, -гөө, -нгаа, -нгээ, -нгоо, -нгөө, -мууни, -мүүни, -муул, -мүүл, -ан, -н, -рн, -хан, -хэн, -эн, -эд, -яа, -ёо, -еэ, -йаа, -йээ.**

Эдгээр нөхцөлөөс:

**-аа (аан), -ээ (ээн), -оо (оон)** нөхцөлийг буриад, дагуур, орчин цагийн монгол хэл болон өвөрмонгол хэлэнд  
**-өө (өөн)** нөхцөлийг буриад, орчин цагийн монгол хэл болон өвөрмонгол хэлэнд  
**-гаа, -гээ, -гоо, -гөө, -нгаа, -нгээ, -нгоо, -нгөө, -яа, -ёо, -еэ** нөхцөлийг буриад хэлэнд  
**-н** нөхцөлийг буриад, халимаг хэлэнд  
**-эд, -йаа, -йээ, -мууни, -мүүни, -муул, -мүүл** нөхцөлийг дагуур хэлэнд  
**-ан, -рн, -хан, -хэн, -эн** нөхцөлийг халимаг хэлэнд хэрэглэнэ.

#### Хоёр.Биеийн хамаатуулах нөхцөл

Нэгдүгээр биеийн нөхцөл:

Ганц биед хамаатуулах: **-м, -мни, -ни, -мини, -минь**

Хэсэг биед хамаатуулах: **-мнай, -най, -маани, -наани, -маань, -мдн**

Хоёрдугаар биеийн нөхцөл:

Ганц биед хамаатуулах: **-шни, -ш, -тнай, -шини, -чн, -чнь, -тн, -чинь, -тань, -тэнь**

Хэсэг биед хамаатуулах: **-тнай, -таани, -тн, -тань, -тэнь**

Гуравдугаар биеийн нөхцөл:

Ганц биед хамаатуулах: **-нь, -гынь, -иини, -йиини**

Хэсэг биед хамаатуулах: **-нь, -иинь, -инь, -ынь, -ь, иинаани, -йиинаани**

Ганц нэгдүгээр биед хамаатуулах:

**-м** нөхцөлийг буриад, халимаг хэлэнд

**-мни, -ни** нөхцөлийг буриад хэлэнд  
**-мини** нөхцөлийг дагуур хэлэнд  
**-минь** нөхцөлийг орчин цагийн монгол хэл болон өвөр монгол хэлэнд хэрэглэнэ.

Хэсэг нэгдүгээр биед хамаатуулах:

**-мнай, -най** нөхцөлийг буриад хэлэнд  
**-маани, -наани** нөхцөлийг дагуур хэлэнд  
**-маань** нөхцөлийг орчин цагийн монгол хэл болон өвөр монгол хэлэнд  
**-мдн** нөхцөлийг халимаг хэлэнд хэрэглэнэ.

Ганц хоёрдугаар биед хамаатуулах:

**-шни, -ш, -тнай** нөхцөлийг буриад хэлэнд  
**-шини** нөхцөлийг дагуур хэлэнд  
**-чн, -чнь, -тн** нөхцөлийг халимаг хэлэнд  
**-чинь, -тань, -тэнь** нөхцөлийг орчин цагийн монгол хэл болон өвөр монгол хэлэнд хэрэглэнэ.

Хэсэг хоёрдугаар биед хамаатуулах:

**-тнай** нөхцөлийг буриад хэлэнд  
**-таани** нөхцөлийг дагуур хэлэнд  
**-тн** нөхцөлийг халимаг хэлэнд  
**-тань, -тэнь** нөхцөлийг орчин цагийн монгол хэл болон өвөр монгол хэлэнд хэрэглэнэ.

Ганц гуравдугаар биед хамаатуулах:

**-нь** нөхцөлийг буриад, халимаг, орчин цагийн монгол хэл болон өвөр монгол хэлэнд  
**-гынь** нөхцөлийг буриад хэлэнд  
**-иини, -йиини** нөхцөлийг дагуур хэлэнд  
**-ийн, -ы, -ий, -ны, -ний** нөхцөлийг орчин цагийн монгол болон өвөр монгол хэлэнд  
**-ын** нөхцөлийг буриад, орчин цагийн монгол, өвөр монгол, халимаг хэлэнд  
**-н** нөхцөлийг буриад, халимаг, орчин цагийн монгол болон өвөр монгол хэлэнд  
**-йиш, -иш** нөхцөлийг дагуур хэлэнд  
**-не** нөхцөлийг монгол хэлэнд  
**-ни, -йи** нөхцөлийг дүншиан хэлэнд  
**-нэ** нөхцөлийг баоань хэлэнд  
**-э, -а, -ин, -гин, -хин** нөхцөлийг халимаг хэлэнд  
**-ай, -эй, -ой, -иин, -гай** нөхцөлийг буриад хэлэнд тус тус хэрэглэнэ.

Эдгээрээс **-ын, -ийн, -ы, -ий, -ны, -ний, -э, -йиш, -иш, -не, -ни, -йи, -нэ, -а, -н, -ин, -гин, -хин, -ай, -эй, -ой, -иин, -гай** нөхцөл биеийн төлөөний үгийг хэлбэржүүлбэл ганц ба хэсэг гурван биеийн аль алинд, тиймгүй бол зөвхөн ганц ба хэсэг гуравдугаар биед хамаатуулна.

Хэсэг гуравдугаар биед хамаатуулах:

**-нь** нөхцөлийг буриад, халимаг, орчин цагийн монгол болон өвөр монгол хэлэнд  
**-инь, -инь, -ынь, -ь** нөхцөлийг буриад хэлэнд  
**-инаани, -йинаани** нөхцөлийг дагуур хэлэнд тус тус хэрэглэж, нэр үгийн хамаатуулах айн утга илтгэдэг.

Өнөөгийн монгол хэлний нэр үгийн хамаатуулах айн утга илтгэх дээрх бүтээвэртэй дүйх нөхцөл “Монголын нууц товчоонд” **-mini, -mani, -çini, -tani, -inu, -anu, -ban, -ben, -и, -ь, -ип, -ьп, -үйп** гэсэн бүтэц, хэлбэртэй байна.

Монгол хэлний нэр үгийн хамаатуулах айн утга илтгэх арга манж-хамниган, казах-түрэг зэрэг бусад алтай хэлнийхтэй үндсэндээ адил бөгөөд гагцхүү тухай тухайн аргыг хэрэглэх хүрээ хэмжээний хувьд ялимгүй ялгаа байна. Өөрөөр хэлбэл, нэр үгийн хамаатуулах ай нийлэг (синтетический способ, synthetic method); задлаг (аналитический способ, analytical method); задлаг-нийлэг (аналитико-синтетический способ, analytical-synthetic method) аргаар илэрдэг боловч, эдгээр аргаас монгол хэлэнд нийлэг, задлаг хоёр арга голлох үүрэгтэй, задлаг-нийлэг арга дагалдсан шинжтэй байна. Үүнд,

Нийлэг аргын жишээ:

Буриад хэл: *Абамни - аав минь, бурхамнай - бурхан маань, алташни - алт чинь, алтатнай - алт тань, намганиинь - гэргий нь, хүбүүдынь - хөвүүд нь, тохомоо - эмээлээ;*

Дагуур хэл: *Варкълмін` - хувцас минь, варкълмйн` - хувцас маань, варкълш`ин` - хувцас чинь, варкълтйн` - хувцас тань, варкъл-лйн` - хувцас нь, нохддомул - нохдодоо, кэкэдэмүүл - мууруудтаа;*

Орчин цагийн монгол болон өвөрмонгол хэл: *Аав минь, ээж маань, ах чинь, эгч тэнь, хүү нь, охин нь, гэртээн, морион, хөлөөн, шаагаан (шагайгаа);*

Халимаг хэл: *Мөрм - морь минь, мөрн мини - морь минь, мөрмдн - морь маань, мөрн чн - морь чинь, мөрн тн - морь тань, мөрнь - морь нь, хариһэн - гарыгаа, һаран - гараа, мөриһэн - морийгоо, мөрэн - морио, ямаһан - ямаагаа, һарарн - гараараа* гэх мэт.

Задлаг аргын жишээ:

Буриад хэл: *Минии мори - миний морь, манай нютаг - манай нутаг, шинии мори - чиний морь, танай гэр - танай гэр, тэрэнэй нюр - түүний нүүр, тэдэнэй саарһан - тэдний цаас, Аламжын мори - Аламжийн морь, морин нюрган - морины нуруу, баяшуулай хүбүүд - баячуудын хөвгүүд;*

Дагуур хэл: *Ииний мори - түүний морь, ааний кэүкэ - тэдний хүүхэд, минии адоо - миний адуу, бэднии гажир - бидний газар, дэүйии чаас - дүүгийн цаас, акайии нок - ахын нохой;*

Орчин цагийн монгол болон өвөр монгол хэл: *Миний ном, бидний дэвтэр, чиний үзэг, танай гэр, түүний ах, тэдний эгч, аавын сургаал, ээжийн ерөөл;*

*Халимаг хэл: мини мори - миний морь, мана назр - манай газар, чини ах - чиний ах, тадна хөн - танай хонь, терүнэ нурһн - түүний нуруу, теднэ мал - тэдний мал, хунын живэр - хун шувууны жигүүр, төрскни заян - эх орны хувь заяа* гэх мэт.

Задлаг-нийлэг аргын жишээ:

*Буриад хэл: Мүнөө шинии араһаа шини харахадамни - Сая чиний араас чинь харахад минь; Энэ эбэр минии һанаһан һанааеымни, бодоһон бодолымни бэлүүлжэ шадаха эбэр - Энэ эвэр миний санасан санааг минь, бодсон бодлыг минь биелүүлж чадах эвэр;*

*Дагуур хэл: Минии кэкумини хажирбэи - Миний хүү минь харьж ирэв; Маани адоомаани хажирсан - Манай адуу маань харьж ирсэн; Бэдний тарэнаань бараан болсон - Бидний тариа маань арвин болсон, Шинии битэгшини эдэрдсэн - Чиний бичиг чинь эвдэрсэн;*

*Орчин цагийн монгол болон өвөрмонгол хэл: Миний бяцхан бүжин минь, Энэ миний дурсамж дүүрэн анхны минь үерхэл, Чиний хар хүн чинь хэн юм бэ?, За тэгээд та бүхний ирсэн зорилго тань биелэв үү, Тэдний ганц хогшил хэрэглэл нь гэвэл энэ;*

*Халимаг хэл: Мини бийм арвн нээнтэдэн чини эцгдчн ирэд . . . - Миний бие минь арван наймтайдаа чиний эцэгт чинь ирээд . . . , Чини сээлэнчн ноормас давулад күүцхлэ яяхмч? - Чиний сааль чинь нормоос даваад гүйцэхлээр яах юм бэ чи?, Нүдм бидн хури, гармдн ут болдмн - Бидний нүд маань хури, гарууд маань урт болно* гэх мэт.

Дээрх гурван аргаар нэр үгийн хамаатуулах айн утга илтгэхэд ерөнхийлөн хамаатуулах нөхцөл *Номоо унш, Нүдээ нээ, Би номоо уншдаг, Бид номоо уншдаг, Тэд бичгээ бичиж байна* (орчин цагийн монгол ба өвөр монгол хэл); *Эхынгээ гарһаа баряад - Эхийнхээ гараас бариад . . . , Ньюр гараа угаагаад - Нүүр гараа угаагаад . . . , Тэрэ уралаа зуунаа - Тэр уруулаа зууна* (буриад хэл); *Хөөткэн сансн - цецн, хуучан хатхсн - урн - Хойдхоо бодогч - цэцэн, хуучнаа хатгагч уран, Туган тээхмн! - Тугаа тайх минь!, Көвүһән ас - Хүүгээ өг, Би эврэн сернэ - Би өөрөө сэзнэ, Бидн зэцгэн авлицнавидн - Бид мэдээгээ авалцана* (халимаг хэл); *Бү нжизэнь хонинаа даалдини - Би өөрөө хонио хариулна, Тэ нжизэнь бүлэнээ даудажсаань - Тэр өөрөө хүүхдээ дуудаж байна, Нжизэnnээ луусанаа танээ күдэ рэба - Өөрийнхөө луусаа танд орхихоор ирлээ, Агунь нжизэнаа ананаа санана - Охин өөрийнхөө ээжээ санана* (монгол хэл); *Аамэ гожэnnээ агунээ мохлээ саагэжсоо - Эх өөрийнхөө охиноо цөхөртлөө хүлээсэн* (баоань хэл) гэх мэтээр чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд *Бийин намтр - Биеийн нам-тар, Өөрийн намтар; Эврэ үнр бийд медгддог - Өөрийн үнэр биед мэдэгддэггүй, Биеийн үнэр биед мэдэгддэггүй* (халимаг хэл) гэх зэргээр бас *өөр (өбэр)* хэмээх төлөөний үгийг *бие (бэй - э)* гэдэг нэр үгтэй эн зэрэгцүүлэн хэрэглэж хамаатуулах утга илтгэдэг. Ингэхдээ энэ хоёр үгийг тус тусад нь юм уу нэг доор хоршуулан хэрэглэж болдог байна.

Монгол хэлний энэхүү *өөр (өбэр)* хэмээх үгийг бусад төрөл хэлний биеийн төлөөний үг, тухайлбал, чуваш хэлний *ебе - би, ебир - бид*, солонгос хэлний *үри - бид*, эртний наран хэлний *варэ - бид* гэдэгтэй; харин монгол хэлний *бие (бэй - э)* гэдэг үгийг манж, шивээ хэлний *бэйэ - бие*, үльч хэлний *бүе - бид* гэх мэт үгтэй гарал төрлөөр нь тус тус холбон үзэж болохын дээр ерөөс, нэр үгийн хамаатуулах айн

бүтээвэр төдийгүй, алтай хэлний үг, нөхцөл бүрийн утга гарал, холбоо хамаарлыг аль болох өргөн хүрээнд олон хэлийг хамруулан, ихээхэн лавшруулан судлах явдал Алтайсудлалын хувьд нэн тулгамдсан чухал асуудлын нэг болоод байгаа бөгөөд аль нэг алтай хэлний дагнасан болон харьцуулсан судалгааг цаашид энэ чиглэлээр тасралтгүй үргэлжлүүлэх эрдэмтэн судлаач нарт дээр өгүүлсэн бүхэн бага боловч тус нэмэр болох болтугай.

## НОМЗҮЙ

- Д.Бадамдорж, *Монгол хэлний утга судлал*, Улаанбаатар, 2001  
М.Базаррагчаа, *Монгол хэлний тийн ялгалын утгыг ангилах нь*, "МУИС, МСХ. ЭШБ".1992  
М.Базаррагчаа, *Монгол хэл*, Улаанбаатар, 2000  
А.А.Бобровников, *Грамматика монгольско-калмыцкого языка*, К.1849  
Чой.Лувсанжав, *Монгол хэлний "тийн ялгалын" тухай*, МУИС. ЭШБ. 141. УБ. 1972  
Ш.Озава, *Монголын нууц товчооны ертөнц*, Улаанбаатар, 2002  
Д.А.Павлов, *Имя существительное*, "Грамматика кальмицкого языка". Элиста. 1983  
К.М.Черемисов, *Бурят-монгольско-русский словарь*, М.1951  
Ц.Шагдарсүрэн, *Монголчуудын утга соёлын товчоон*, Улаанбаатар, 1991

## SUMMARY

Possession in Mongolian marked using possessive suffixes such as *-aa (аан)*, *-ээ (ээн)*, *-оо (оон)*, *-өө (өөн)*, *-гаа*, *-гээ*, *-гоо*, *-гөө*, *-нгаа*, *-нгээ*, *-нгоо*, *-нгөө*, *-мууни*, *-мүүни*, *-муул*, *-мүүл*, *-ан*, *-н*, *-рн*, *-һан*, *-һэн*, *-эн*, *-эд*, *-яа*, *-ёо*, *-еэ*, *-йаа*, *-йэд*, *-м*, *-мни*, *-ни*, *-мини*, *-минь*, *-мнай*, *-най*, *-маани*, *-наани*, *-маань*, *-мдн*, *-ини*, *-и*, *-тнай*, *-шини*, *-чн*, *-чнь*, *-тн*, *-чинь*, *-тань*, *-тэнь*, *-тнай*, *-таани*, *-тн*, *-тань*, *-тэнь*, *-нь*, *-гынь*, *-иини*, *-йиини*, *-нь*, *-шинь*, *-инь*, *-ынь*, *-ь*, *-иинаани*, *-йиинаани*, *-ын*, *-ийн*, *-ы*, *-ий*, *-ны*, *-ний*, *-д*, *-йии*, *-ии*, *-не*, *-ни*, *-йи*, *-нэ*, *-а*, *-н*, *-ин*, *-гин*, *-һин*, *-ай*, *-эй*, *-ой*, *-шин*, *-гай* and formed by synthetic method; analytical method and analytical-synthetic method.